



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

---

**Гүйцэтгэлийн аудитын тайлан**

**Цахилгаан шугам сүлжээний газрын 2017 оны  
үйл ажиллагааны үр дүн**

**Хөдөө сумдын цахилгааны алдагдал 34,4  
хувьтай байгаа нь нийт алдагдлын хувьд  
нөлөөлсөн байна.**

# АГУУЛГА

<b>Тайланг бэлтгэсэн:</b>	Товчилсон үгийн тайлбар .....3
<b>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар</b>	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4
Дарга, тэргүүлэх аудитор М. Хуанган	<b>Бүлэг 1</b> <b>Цахилгаан шугам сүлжээний газрын үндсэн үйл ажиллагааны зорилтын хэрэгжилтийн талаар</b>
Аудитын менежер Х.Женисбек	1.1 Удирдах зөвлөлөөс 2017 оны үйл ажиллагааг “хангалттай” гэж дүгнэжээ.....5
Ахлах аудитор Х.Манаргүл	1.2 Хөдөө сумдын цахилгааны алдагдал 34,4 хувьтай байгаа нь нийт алдагдлын хувьд нөлөөлсөн байна.....7
Аудитор Х.Еркебулан	<b>Бүлэг 2</b> <b>Цахилгаан шугам сүлжээний газрын орлогын бүрдүүлэлт, хөрөнгийн зарцуулалтын талаар</b>
<b>2018 оны 7 дугаар сар</b>	2.1. Цахилгааны худалдан авах, түгээх үйлчилгээний үнэ тариф өссөн нь борлуулалт өсөхөд нөлөөлсөн байна.....12
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70422930, 70422954 дугаарын утсаар харилцана уу	2.2. Үйл ажиллагааны зардлыг 171,2 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.....14
<b>ХАЯГ:</b>	2.3. Олон жил он дамжсан байгууллага, хувь хүмүүсээс авах авлага, найдваргүй авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна .....17
<b>Аймгийн ЗДТГазрын байр, 1 дүгээр давхар</b>	<b>Бүлэг 3. Дотоод хяналтын талаар</b>
	3.1 Сумын салбаруудын арилжааны банк дахь харилцах дансанд оны эцэст 0,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. ....18
	3.2 Хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим хөрөнгийг орлого аваагүй байна. ....19
	3.3 Дотоод хяналт шалгалт үр нөлөөгүй, үр дүн муутай хэрэгжсэн байна..... 20
	<b>Дүгнэлт.....22</b>
	<b>Зөвлөмж.....23</b>
	<b>Холбогдох байгууллагын санал:</b>
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал ... ..24
	<b>Саналд өгсөн тайлбар .....</b>

## Товчилсон үгийн тайлбар

<b>АИТХ</b>	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>УЗ</b>	Удирдах зөвлөл
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар
<b>ЦШСГ</b>	Цахилгаан шугам сүлжээний газар
<b>ЦДАШ</b>	Цахилгаан дамжуулах агаарын шугам
<b>ББЭХС</b>	Баруун бүсийн эрчим хүчний систем
<b>ААН</b>	Аж ахуйн нэгж
<b>ББЭХС ТӨХК</b>	Баруун бүсийн эрчим хүчний систем төрийн өмчийн хувьцаат компани
<b>ЭХЗХ</b>	Эрчим хүчний зохицуулах хороо
<b>СИП</b>	Сип кабель
<b>БОШХ</b>	Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ
<b>ТУГУБ</b>	Тоолуурыг унших гар удирдлагын багаж

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

### Аудитын зорилт

Аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ЦШСГазрын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг сайжруулах, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх дүгнэлт, зөвлөмж гарган үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго оршино.

### Хамарсан хүрээ

Гүйцэтгэлийн аудитад ЦШС-ний газрын удирдах зөвлөл болон бусад холбогдох байгууллагуудаас гаргасан холбогдох шийдвэрүүд, зохион байгуулсан ажлын үр дүн, ЦШС-ний газрын үйл ажиллагаатай холбоотой 2017 оны санхүүгийн болон ажлын тайлан, санхүүгийн барим материалууд хамрагдлаа.

### Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглав.

### Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг ахлах аудитор Х.Манаргүл ахалж, аудитор Х.Еркебулан нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг 2018 оны 5 сарын 24-нөөс 7 сарын 03-ны дотор аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, ажлын хуваарийн дагуу хийж, аудитын тайланг боловсруулав.

# Бүлэг 1

**Хөдөө сумдын цахилгааны алдагдал 34,4 хувьтай байгаа нь нийт алдагдлын хувьд нөлөөлсөн байна.**

## Оршил

Цахилгаан шугам сүлжээний газар /ЦШСГ/нь Баруун бүсийн эрчим хүчний системээс цахилгаан дамжуулах, цахилгаан үйлдвэрлэх, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэвийн үйл ажиллагаа болон хэрэглэгчийн цахилгааны хэрэглээг найдвартай хангах, дамжуулах сүлжээг ашиглах, засвар үйлчилгээ хийх, өргөтгөх үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн өмчийн үйлдвэрийн газар юм.

Цахилгаан шугам сүлжээний газрыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн томилсон Удирдах зөвлөл удирддаг бөгөөд гүйцэтгэх захирлыг томилох болон үйл ажиллагаа явуулахтай холбоотой хөрөнгө, санхүү бодлогын асуудлууд, тайланг хэлэлцэн шийдвэр гарган ажилладаг байна.

Тус газар нь захиргаа аж ахуй, ашиглалт засварын, дизель станцын, борлуулалтын гэсэн 4 хэсэгтэй бөгөөд 1537 аж ахуйн нэгж, албан байгууллага, 14530 айл өрхийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангаж ажилласан байна.

ЦШСГазар нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2007 оны 142 дугаар тогтоолоор цахилгаан эрчим хүч түгээх, хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр зохицуулалттайгаар найдвартай хангах, тоолуур хэмжих хэрэгсэл шалгах тусгай зөвшөөрлийг авч үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

## **1. Цахилгаан шугам сүлжээний газрын үндсэн үйл ажиллагааны зорилтын хэрэгжилтийн талаар.**

### **1.1 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар.**

*Удирдах зөвлөлөөс 2017 оны үйл ажиллагааг “хангалттай” гэж дүгнэжээ.*

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 135 дугаар тогтоолоор ЦШСГазрын Удирдах зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Удирдах зөвлөлийн даргаар аймгийн ИТХ-ын дарга, гишүүдээр нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгч гишүүн, аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Нэгдсэн эмнэлгийн орлогч, ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга нарыг томилон ажиллуулсан байна. Дээрх тогтоолоор тус газрын менежментийг сайжруулж, үйлдвэрлэлийг үр ашигтай ажиллуулах бүх талын арга хэмжээ авч ажиллахыг Удирдах зөвлөлд даалгажээ.

Удирдах зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор газрын 2017 оны үйл ажиллагааны бизнес санхүүгийн төлөвлөгөөг баталсан байна.

2017 оны бизнес санхүүгийн төлөвлөгөөг хураангуйлан харуулбал:

/сая төгрөгөөр/

<b>Үзүүлэлт</b>	<b>Төлөвлөгөө</b>	<b>Гүйцэтгэл</b>	<b>зөрүү</b>
<b>Нийт борлуулалтын орлого</b>	<b>4,511.7</b>	<b>5,792.3</b>	<b>1,280.6</b>
Борлуулалтын орлого	4,390.9	5,732.0	1,341.1
Үйл ажиллагааны бус орлого	120.8	60.3	- 60.5
<b>Үйл ажиллагааны нийт зардал</b>	<b>5,244.4</b>	<b>6,055.1</b>	<b>810.7</b>
Үйл ажиллагааны зардал	1,630.5	1,459.3	-171.2
Элэгдлийн зардлын дүн	770.0	776.1	6.1
Орлогын албан татвараас бусад зардал	5.1	3.9	- 1.2
Ажиллагсдын нийгмийн зардал	185.4	108.1	- 77.3
Үйл ажиллагааны бус зардал /Цахилгааны өртөг/	2,653.4	3,707.7	1,054.3
<b>Үйл ажиллагааны ашиг, алдагдал</b>	<b>732.7</b>	<b>262.8</b>	<b>- 469.9</b>

/Эх сурвалж: ЦШСГ-ын тайлангаас/

2017 оны үйл ажиллагаанаас 4511,7 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөсний 97,3 хувийг борлуулалтын орлогоос, 2,7 хувийг үйл ажиллагааны бусад орлогоос оруулахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 5792,3 сая төгрөгийн орлого оруулсны 99,0 хувь буюу 5732,0 сая төгрөгийг борлуулалтын орлогоос, 1,0 хувь буюу 60,3 сая төгрөгийг үндсэн бус үйл ажиллагааны орлогоос оруулж, орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 1280,6 сая төгрөгөөр буюу 28,4 хувиар давж биелэгджээ.

Үйл ажиллагааны зардалд нийт 5244,4 сая төгрөгийн хөрөнгө зарцуулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 6055,1 сая төгрөг зарцуулж 810,7 сая төгрөгөөр хэтэрч, 262,8 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж алдагдал төлөвлөснөөс 469,9 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Үйл ажиллагааны зардал 171,2 сая төгрөгөөр, орлогын албан татвараас бусад зардал 1,2 сая төгрөгөөр, ажиллагсдын нийгмийн зардал 77,3 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

Бүтэц орон тоог удирдлага 3, захиргаа аж ахуй 14, борлуулалтын хэсэг 52, ашиглалт засварын хэсэг 12, дизелийн хэсэг 9 бүгд 90 орон тоо батлагдаж, гүйцэтгэлээр 91 орон тоогоор үйл ажиллагаа явуулжээ. Удирдах зөвлөлийн 2016 оны 02 тоот тогтоолоор дотоод хяналт шинжилгээний ажилтны орон тоог шинээр авч ажиллуулснаас орон тоо 1-ээр хэтэрчээ.

Эрчим хүч зохицуулах хорооны 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 95 дугаар тогтоолоор “Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨҮААГ-ын цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлүүдийн нөхцөл, шаардлагын 2017 онд мөрдөж ажиллах зорилтыг батлуулан, биелэлтийг дүгнүүлж ажилласан байна.

Эрчим хүчний зохицуулах хорооноос тус компани цахилгаан түгээх зорилтын биелэлтийг 79,9 хувиар, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлүүдийн нөхцөл, шаардлагын зорилт биелэлтийг 95,0 хувиар дүгнэж 2017 оны зорилтын биелэлтийг “сайн” үнэлгээгээр дүгнэсэн байна.

Удирдах зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар ЦШСГ-ын 2017 оны үйл ажиллагааг “хангалттай” гэж дүгнэсэн байна.

Удирдах зөвлөлийн 2017 оны хурлаар үндсэн хөрөнгө худалдан авах, бүртгэх, шилжүүлэх, актлах журам, мөн ажилтнуудад жилийн үйл ажиллагааны үр дүнгээр шагнал урамшил олгох журмыг тус тус баталж мөрдөж ажилласан байна.

## 1.2 Цахилгаан эрчим хүчээр хангах зорилтын хэрэгжилтийн талаар.

*Хөдөө сумдын цахилгааны алдагдал 34,4 хувьтай байгаа нь нийт алдагдлын хувьд нөлөөлсөн байна.*

Цахилгаан шугам сүлжээний газар нь 2017 онд аймгийн төвийн 580-аад аж ахуйн нэгж, байгууллага, 15000 айл өрх, баруун бүсийн сүлжээнд холбогдсон 13 сум, 29 багийн төвийн хэрэглэгчдийн цахилгааны хэрэглээг хангах, дамжуулах сүлжээг ашиглах, засвар үйлчилгээ хийх, өргөтгөх үйл ажиллагааг хийж, хэрэглэгчдийг ББЭХС-ээс 110 кв, 35 кв, 15 кв, 10 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаар дамжуулан цахилгаан эрчим хүчээр хангаж ажилласан байна.

Тус газар нь захиргаа аж ахуй, шугам сүлжээний, борлуулалтын, дизель станцын гэсэн 4 хэсэг нэгжээр хэрэглэгчдийн цахилгаанаар найдвартай хангах, цахилгаан тасрах үед нөөц эрчим хүчээр хангах дизель станцыг байнгын бэлэн байдалтай ажиллуулж ирсэн байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2015 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 201 дугаар тогтоолоор баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийн үнэ тарифыг индексжүүлж үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага болон айл өрхөд борлуулах цахилгааны тариф, тоолуургүй ахуйн хэрэглэгчдийн цахилгааны төлбөр тооцох сарын дундаж хэрэглээг тус тус баталсныг мөрдөж ажилласан байна.

Энэхүү тарифаар уул уурхай олборлох, боловсруулах үйлдвэрүүдэд борлуулах цахилгааны тарифыг 1 квт цагт 151 төгрөг 60 мөнгөөр, үйлдвэр аж ахуйн газарт 124 төгрөг 20 мөнгөөр, айл өрхөд 86 төгрөг 80 мөнгөөр, айл өрхийн сарын суурь тарифыг сард 2000 төгрөгөөр, тоолуургүй айл өрхийн 1 квт цагийн тарифыг 350 төгрөгөөр тогтоосон байна.

Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2015 оны 7 сарын 10-ны өдрийн 212 дугаар тогтоолоор баруун бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийн сэргээгдэх эрчим хүчийг дэмжих 1 квт цагийн тарифыг 8 төгрөг 30 мөнгөөр тогтоосон ба Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2017 оны 7 сарын 17-ны өдрийн 211 тоот тогтоолоор 1 квт цагийн тарифыг 3 төгрөг 58 мөнгөөр нэмэгдүүлж тогтоосон байна.

ББЭХ-ний системээс 2017 онд худалдан авах цахилгааны хэмжээг дараах байдлаар төлөвлөсөн байна. Үүнд:

Үзүүлэлт	Худалдан авах цахилгаан /мян.квт.цаг/		Зөрүү	хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>Жилийн дүн</b>	<b>41,838.0</b>	<b>44,293.8</b>	<b>2,455.8</b>	<b>5.8</b>
Алдагдал хувиар	18.0	17.18	- 0.82	- 4.6

Алдагдал тоогоор	7,535.0	7,610.7	75.7	1.0
Цэвэр борлуулах цахилгаан	34,303.0	36,683.1	2,380.1	6.8

/Эх сурвалж: ЦШСГ-ын тайлангаас/

Хүснэгтээс үзэхэд 41838,0 мян.квт.цаг цахилгаан эрчим хүч худалдан авахаар төлөвлөж, 44293,8 мян.квт.цаг цахилгаан эрчим хүч худалдан авч 2455,8 мян.квт.цаг буюу 5,8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Тайлант онд нийт худалдан авалтын 18 хувь буюу 7535,0 мянган квт/цаг цахилгааныг шугамын алдагдлаар тооцож, 34303,0 мянган квт/цаг цахилгаан борлуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 17,18 хувь буюу 7610,7 мянган квт/цаг цахилгааны шугамын алдагдал гарч 36683,1 мянган квт/цаг цахилгаан борлуулжээ. Энэ нь 2017 онд цахилгааны хэрэглээ өссөнтэй холбоотой байна.

ББЭХ-ний системээс худалдан авсан цахилгаан эрчим хүчний хэмжээ, алдагдлыг 2016 онтой харьцуулж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлт		Худалдан авах цахилгаан /мян.квт.цаг/				Алдагдал хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь	
2016 он	<b>Нийт дүн:</b>	<b>40,711.0</b>	<b>33,336.0</b>	<b>-7,375.0</b>	<b>100.0</b>	<b>18.1</b>
	Хөдөө сумд	11,194.0	7,372.0	-3,822.0	22.1	34.1
	Аймгийн төвд	29,517.0	25,964.0	-3,553.0	77.9	12.0
2017 он	<b>Нийт дүн:</b>	<b>44,293.8</b>	<b>36,683.1</b>	<b>-7,610.7</b>	<b>100.0</b>	<b>17.18</b>
	Хөдөө сумд	11,919.0	7,823.0	-4,096.0	21.3	34.4
	Аймгийн төвд	32,374.8	28,860.1	-3,514.7	78.7	10.8
Өсөлт /бууралт /2016-2017/	<b>Нийт дүн:</b>	<b>- 3,582.8</b>	<b>- 3,347.1</b>	<b>- 235.7</b>	<b>-</b>	<b>0.92</b>
	Хөдөө сумд	- 725.0	- 451.0	- 274.0	13.5	- 0.26
	Аймгийн төвд	- 2,857.8	- 2,896.1	38.3	86.5	1.3

/Эх сурвалж: ЦШСГ-ын тайлангаас/

2017 онд ББЭХС ТӨХК-аас нийтдээ 44293,8 мянган квт/цаг цахилгаан худалдан авч 26.9 хувь буюу 11919,0 мянган квт/цагийг хөдөө сумдад, 73.1 хувь буюу 32374,8 мянган квт/цагийг аймгийн төвд борлуулахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 36,683.1 мянган квт/цаг цахилгаан худалдан авч 21,3 хувь буюу 7823,0 мянган квт/цагийг хөдөө сумдад, 78,7 хувь буюу 28860,1 мянган квт/цагийг аймгийн төвд түгээн борлуулсан байна.

2017 оны цахилгаан худалдан авалтын төлөвлөгөө өмнөх оноос 8,8 хувь буюу 3582,8 мянган квт/цагаар, гүйцэтгэл 10,0 хувь буюу 3347,1 мян.квт.цагаар тус тус өсч, түгээлтийн алдагдал 0,92 хувиар буурсан байна.

Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 95 дугаар тогтоолоор цахилгаан, түгээх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын 2017 онд мөрдөж ажиллах зорилтод эзэмшигчдийн цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдлыг Баян-Өлгий аймагт 18 хувиас хэтрүүлэхгүй байхаар тогтоожээ. Тайлант онд цахилгааны алдагдал нь Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс тогтоосон хувиас 0,82 хувиар бага буюу 17,18 хувийн алдагдалтай ажилласан байна.



Сумуудын сүүлийн 3 жилийн цахилгааны алдагдлын хувийг хүснэгтээр харуулахад дараах байдалтай байна.

Онүүд	Алдагдлын хувь				
	1-10%	11-20%	21-30%	30-40%	40-50%
2015	Улаан байшин		Алтанцөгц, Буянт, Ногооннуур, Сагсай, Улаанхус, Цагааннуур тосгон, бусад багууд	Алтай, Баяннуур, Бугат, Булган, Дэлүүн, Толбо, Цэнгэл, Согог, Хөх хөтөл,	
2016	Улаан байшин	Буянт, Улаанхус,	Алтай, Алтанцөгц, Бугат, Сагсай, Цэнгэл, Ногооннуур, Согог,	Булган, Дэлүүн, Толбо, Хөх хөтөл, Цагааннуур тосгон	Баяннуур,
2017	Хөх хөтөл	Алтай, Бугат, Буянт, Сагсай, Улаанхус, Согог, Улаан байшин	Алтанцөгц, Цэнгэл,	Дэлүүн, Ногооннуур, Толбо, Цагааннуур	Баяннуур, Булган

/Эх сурвалж: ЦШСГ-ын тайлангаас/

Хүснэгтээс харахад 2017 онд ихэнх сумын цахилгааны алдагдал 11-20 хувьтай, зарим сумын цахилгааны алдагдал 30-аас дээш хувьтай байна. Хөдөө сумдын цахилгааны алдагдлын дундаж 34,4 хувьтай, аймгийн төвийн алдагдал 10,8 хувьтай ба нийт алдагдал дунджаар 17,18 хувьтай гарч аймгийн төвийн цахилгааны алдагдлын бууралт нь нийт алдагдлын хувь буурахад нөлөөлжээ.

Сумуудын худалдан авсан цахилгааны хэмжээ аймгийн төвөөс гурван дахин бага боловч түгээлтийн алдагдал нь нийт алдагдлын 53,8 хувийг эзэлж байна. Зарим сумуудын 0,4 кв-ын шугам хуучирсан, шинэчлэлт хийгдээгүйгээс техникийн болон үйл ажиллагааны алдагдал 30,0-47,0 хувьтай гарчээ. Энэ нь сумуудын цахилгааны алдагдлыг бууруулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

Тайлант онд цахилгаан тасалдалтыг багасгах, эрчим хүч дамжуулах сүлжээг сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийн найдвартай цахилгаанаар хангах талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 250,0 сая төгрөгөөр 920 айл өрхийг ухаалаг тоолуурын системд холбосноор алсын зайнаас тоолуурын заалт авах, таслалт залгалт хийх боломжтой болжээ. Ингэснээр хүний хөдөлмөр хөнгөвчлөх, хувь хүнээс үүдэн гарах /заалт буруу харах/ зэрэг эрсдэлүүд буурсан байна.

Аймгийн төвийн цахилгаан түгээлтийн алдагдал нь ухаалаг тоолуур тавихаас өмнөх 2016 оны дунджаар 12,0 хувьтай байсан бол 2017 онд 10,8 хувь болж 1,2 хувиар буурсан байна.

Ухаалаг тоолуурыг орон сууцанд DDS-121 марк, гэр хороололд DDS-121G маркийн БНХАУ-ын “Мирал” компанид үйлдвэрлэсэн тоолуурыг суурилуулж, ухаалаг тоолуурын системийн программ хангамжийг тус компанид хийлгэсэн программыг ашигласан байна. Мөн албан байгууллага, хувь хүний нэхэмжлэл хэвлэн авах, онлайнаар цахилгааны төлбөрөө төлөх, төлсөн баримтын НӨАТ-ыг шууд хэвлэж авах, хэрэглэгчийн цаг хугацааг хэмнэж төлбөрийг онлайнаар хийх боломж бүрдсэн

байна. Аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдийн хэрэглээг [www.olgiitugeex.mn](http://www.olgiitugeex.mn) вэб сайтаар онлайнаар хянах боломжтой болжээ.

2016 онд орсон хүчтэй аадар борооны улмаас орон гэргүй болсон иргэдэд зориулж тусламжаар барьж ашиглалтад оруулсан шинэ кувейт хорооллын цахилгаан хангамжийн ажлыг хийж гүйцэтгэж, ББЭХС ТӨХК-ын Өлгий дэхь хувиарлах байгууламжаас Дизелийн хуваарилах байгууламж хүртэлх 10кВ-ийн агаарын шугамд үзлэг хийн изоляторуудыг сольсон байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Өлгий сумын 2,3,10,13-д багуудад 35,8 сая төгрөгийн СИП кабель 0,4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих, Ногооннуур сумын Хүүхдийн цэцэрлэгт цахилгаан шугам татах 4,0 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэж ашиглалтанд оруулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Өлгий сумын 13 дугаар багт 18 айлын цахилгаан шугам татах 4,5 сая төгрөгийн, Улаанхус сумын Согоог багт трансформатор тавих 10,0 сая төгрөгийн, Өлгий сумын 13-р багт орон сууцны трансформатор тавих 24,0 сая төгрөгийн, 13-р багийн үйлдвэрийн бүсийн трансформатор тавих 28,0 сая төгрөгийн, Замын сангийн хөрөнгөөр Өлгий сумын 8-р багт гэрлэн дохио 16,0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг тус тус хэрэгжүүлжээ.

Аймгийн төвд ачаалал нь ихдэж хүчдэл буурч буй 5, 11 дүгээр багт 250 кВ чадалтай хоёр дэд станц барьж хүчин чадлыг нэмэгдүүлж, 12 дугаар багийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах СИП кабель хайрцаг тоолууржуулах ажлыг хийж гүйцэтгэжээ.

Сагсай сумын Битүү, Баяннуур сумын Цэцэгт багийн 22 кВ-ийн буцах газардуулгатай нэг фазын шугамын өсгөх, бууруулах трансформаторыг Увс аймгаас авч ирж суурилуулан хэвийн ажиллах нөхцөлийг хангаж, Улаанхус, Сагсай сумуудад дэд станц барьж ашиглалтад оруулан, Улаанхус сумын Согоог багийн АТП-2, Цэнгэл сумын Зэгт, Цагаан гол багийн АТП-д гэмтсэн трансформаторуудыг сольсон байна.

Бугат сумын 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчилж аймгийн төвийн шугамд холбосноор тус сумын 2016 онд 29.8 хувьтай байсан алдагдал 18,6 хувь болж буурсан байна

Булган сумын арван гурван багана тэгшилж, найман багана хооронд шугам чангалж, 15кВ-ын лонх 420 ширхэг шинээр сольж, 430 баганы лонхны уяаг шинээр хийсэн байна.

Алтай, Буянт, Дэлүүн, Толбо, Алтанцөгц, Улаанхус сум, Улаанхус сумын Хөх хөтөл, Согог, Баяннуур сумын Цагаан арал багуудад цаг агаарын болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр өндөр хүчдэл тасарсныг засаж, үйл ажиллагааг нь хэвийн байдалд оруулж, гарсан гэмтлийг тухай бүрд засаж ажиллажээ.

Аймгийн төвийн болон зарим сумуудад график төлөвлөгөөний дагуу тоолуур баталгаажуулах ажлыг гүйцэтгэж электрон тоолуурыг /импульс/ 4 жилд 1 удаа, механик тоолуурыг 3 жилд 1 удаа баталгаажуулалтад хамруулсан байна.

Стандарт хэмжилзүйн хэлтэстэй хамтран Буянт сумд 131, Толбо сумд 52, Дэлүүн сумд 93 механик тоолуурыг, Улаанхус сумд 182, Улаанхус сумын Хөх хөтөл багт 81, Улаанхус сумын Согоог багт 59, Өлгий сумын 882 электрон тоолуур нийт

1480 тоолуурыг баталгаажуулж, стандартын шаардлага хангаагүйг 59 тоолуурыг хэрэгцээнээс хассан байна.

Аймгийн төвийн айл өрхүүдэд тавьсан ухаалаг тоолуурыг МХГазар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, тус газрын холбогдох мэргэжилтэн, хэрэглэгчийн төлөөллийг оролцуулан, хэмжилт хийж, баталгаат хугацааг 8 жилээр тооцсон байна.

Сумын байцаагч нараас цахилгааны борлуулалт, барагдуулалт, өр, авлага, алдагдлын мэдээг сар бүр тогтмол гаргуулж, ажлын үр дүнгээр цалинжуулсан байна.

Сумдын дэд станцуудад хэмжилт хийж, фаз тэнцүүлэх арга хэмжээг тогтмол хийдэг болсон байна.

## Бүлэг 2

*Найдваргүй авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.*

### 2. Орлогын бүрдүүлэлт, хөрөнгийн зарцуулалтын талаар.

#### 2.1 Борлуулалтын орлого, бусад орлогын бүрдүүлэлт, тооцооны талаар.

*Цахилгааны худалдан авах, түгээх үйлчилгээний үнэ тариф өссөн нь борлуулалт өсөхөд нөлөөлсөн байна.*

Цахилгаан шугам сүлжээний газар нь 2017 онд борлуулалтын орлогоос 5732,0 сая төгрөгийн, бусад орлогоос 60,3 сая төгрөгийн нийтдээ бүгд 5792,3 сая төгрөгийн орлого оруулж, орлогын төлөвлөгөөг 1280,6 сая төгрөгөөр буюу 28,4 хувиар давуулан биелүүлжээ.

Борлуулалтын нийт орлогын 55,2 хувийг буюу 3166,7 мянган төгрөгийг “ХААН”, “Хас”, “Голомт”, “Төрийн банк”, Капитрон”, “Капитал” банкин дахь харилцах дансанд, 44,8 хувийг буюу 2565,3 мянган төгрөгийг борлуулалтын хоёр касст орсон байна. Борлуулалтын касст орсон орлогын тооцоог өдөр бүр хийж “Хас”, “Голомт” банк дахь харилцах дансуудад төвлөрүүлж ажиллажээ.

Цахилгаан эрчим хүчний хэрэглээний бүтэц, борлуулалтын орлогыг өмнөх оны гүйцэтгэл, тайлант оны төлөвлөгөөтэй харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	2016 оны Борлуулалтын орлого /сая төг/	2017 оны Борлуулалтын орлого /сая төг/		Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өмнөх оноос	Төлөвлөгөө нөөс
Үйлдвэрлэлийн байгууллага	1,383.9	1,454.5	1,785.7	401.8	331.2
Худалдаа үйлчилгээний байгууллага	410.9	465.5	598.9	188.0	133.4
Төсвийн байгууллага	308.9	295.9	452.6	143.7	156.7
Орон сууц	247.2	300.3	465.6	218.4	165.3
Гэр хороолол	1,239.1	1,285.6	1,753.6	514.5	468.0
Сумууд	645.6	589.1	675.6	30.0	86.5
<b>ДҮН</b>	<b>4,235.6</b>	<b>4,390.9</b>	<b>5,732.0</b>	<b>1,496.4</b>	<b>1,341.1</b>

/Эх сурвалж: ЦШСГ-ын тайлангаас/

Борлуулалтын орлогын бүтцийг авч үзвэл: Үйлдвэрлэлийн байгууллагаас 31,2 хувийг, худалдаа үйлчилгээний байгууллагаас 10,4 хувийг, төсвийн байгууллагаас 7,9 хувийг буюу, орон сууцнаас 8,1 хувийг, гэр хороололоос 30,6 хувийг, сумуудаас 30,0 хувийг тус тус оруулсан байна.

Борлуулалтын орлого өмнөх оны гүйцэтгэлээс 1496,4 сая төгрөгөөр, тайлант оны төлөвлөгөөнөөс 1341,1 сая төгрөгөөр өссөн байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 5 дугаар сарын 148 дугаар, 2017 оны 9 сарын 221 дүгээр тогтоолоор “ББЭХС” ТӨХК-иас худалдаж авах цахилгааны тариф (НӨАТ-гүй) болон түгээх үйлчилгээний төлбөрийн тарифыг нэмсэн нь борлуулалтын орлого өсөхөд нөлөөлсөн байна.

Тухайлбал: Эрчим хүчний зохицуулах хорооны 148 дугаар тогтоолоор “ББЭХС” ТӨХК-иас худалдаж авах цахилгааны тариф (НӨАТ-гүй)-ыг 99,87 төг/кВт.ц, “ББЭХС” ТӨХК-д түгээх үйлчилгээний төлбөрийг 159252,7 мянган төгрөгөөр, 221 дүгээр тогтоолоор “ББЭХС” ТӨХК-иас худалдаж авах цахилгааны тариф (НӨАТ-гүй)-ыг 98,05 төг/кВт.ц, түгээх үйлчилгээний төлбөрийг 194502,4 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн баталсныг мөрдөж ажиллажээ.

2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 221 тоот тогтоолын тарифын зохицуулалтаар Цэнгэл сумын цахилгаан хангамж сайжруулахад шаардлагатай 250,0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын үр өгөөжөөр шийдвэрлүүлсэн байна.

ББЭХ-ний системээс худалдан авч буй болон борлуулж буй цахилгааны үнийн өсөлтийг сүүлийн 3 жилээр харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

	2015 оны 7 сарын 25		2016 он		2017 он		2017 он	
	үнэ	өсөлтийн хувь	үнэ	өсөлтийн хувь	үнэ	өсөлтийн хувь	үнэ	өсөлтийн хувь
Худалдан борлуулах үнэ								
ААН байгууллага	132,5	17,2						
Айл өрх	95,1	20,3						
	2015 оны 7 сарын 25		2016 он		2017 оны 06 сарын 01-нээс		2017 оны 09 сарын 01-нээс	
ББЭХ-ээс худалдан авч буй цахилгаан	63,42	28,3			99,87	57,5	98,05	-1,8

/Эх сурвалж: ЦШСГ-ын тайлангаас/

Дээрх хүснэгтээс үзэхэд аж ахуйн нэгж байгууллага, айл өрхийн цахилгааны үнэ 2015 оны 7 дугаар сараас хойш нэмэгдээгүй бөгөөд ББЭХ-ээс худалдан авч буй цахилгааны үнэ 2017 оны 06 дугаар сард 36,45 төгрөгөөр нэмэгдэж, 09 дүгээр сарын 01-нээс нэмэгдсэн дүнг 1,8 хувиар бууруулж 98,05 төгрөгөөр тогтоосон байна

Борлуулалтын орлогоос ББЭХС-д худалдан авсан цахилгааны өртөгт 2953,3 сая төгрөгийг төлсөн байна.

Бусад орлогыг нэр төрлөөр нь хүснэгтээр харуулбал:

№	Үзүүлэлт	Бичилт хийх цэгийн тоо	Жилийн орлого		Зөрүү
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Цахилгаан бичилтээс	16850	21,8	5,6	-16,2
2	Шинэ холболт	47	27,9	6,8	21,1
3	Төлбөрийн зөрчлөөс болж цахилгаан түтгэлзүүлсэнээс	165	4,9	1,2	-3,7

	орох орлого				
4	МҮОНТ-ийн хураамжаас орох орлого	7930	59,9	17,3	-42,6
5	Бусад орлого	0	0,9		-0,9
Хүүгийн орлого			5,4	29,4	24,0
<b>Бүгд дүн</b>		<b>24992</b>	<b>120,8</b>	<b>60,3</b>	<b>-60,5</b>

/Эх сурвалж: ЦШСГ-ын тайлангаас/

Бусад орлогоос 60,3 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөө 60,5 сая төгрөгөөр тасарчээ. Хүүгийн орлого 24,0 сая төгрөгөөр давж, цахилгааны бичилт, шинэ холболт, цахилгаан түдгэлзүүлсний хураамж, МҮОНТ-ийн хураамж, бусад орлогын төлөвлөгөө 0,9-42,6 сая төгрөгөөр тасарсан байна.

## 2.2 Үйл ажиллагааны зардалд хуваарилагдсан хөрөнгийн талаар.

*Үйл ажиллагааны зардлыг 171,2 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.*

2017 онд үйл ажиллагааны зардалд нийтдээ 5244,4 сая төгрөгийн хөрөнгө зарцуулахаар батлагдсаны 1630,5 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд, 770,0 сая төгрөгийг элэгдлийн зардалд, 185,4 сая төгрөгийг ажиллагсдын нийгмийн зардалд, 5,1 сая төгрөгийг бусад зардал, 2653,4 сая төгрөгийг худалдан авсан цахилгааны үнэд төлж, 732,7 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үйл ажиллагааны зардалд 1459,3 сая төгрөгийг, элэгдлийн зардалд 776,1 сая төгрөгийг, орлогын албан татвараас бусад зардалд 3,9 сая төгрөгийг, ажиллагсдын нийгмийн зардалд 108,1 сая төгрөгийг, худалдан авсан цахилгааны үнэд 3707,7 сая төгрөгийг төлж нийтдээ 6055,1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Захиргаа аж ахуйн зардалд нийт 1630,5 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 1459,2 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 171,2 сая төгрөгөөр хэмнэжээ.

Зардлын зүйл ангиар авч үзвэл: сэлбэг хэрэгсэл, цалин, НДШ, албан томилолт, хөдөлмөр хамгаалал, бичиг хэрэг, галын аюулаас хамгаалах, борлуулалт маркетинг, үйлчилгээний хөлс, үйл ажиллагааны бусад зардал 0,9-111,4 сая төгрөгөөр хэтэрч, шатахуун, сэлбэг хэрэгсэл, урсгал засвар, хангамжийн материал, ашиглалт, дизель станц, халаалт, конторын хангамж, холбоо, түрээс, зохицуулалт үйлчилгээний зардал, банкны үйлчилгээ, сургалтын зардал 0,3-14,1 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Хөдөлмөр хамгааллын зардалд 33,9 сая төгрөг төлөвлөж 21,9 сая төгрөг зарцуулж, 11,9 сая төгрөгөөр хэмнэжээ. Энэ нь хөдөлмөрийн хувцасны элэгдлийн хугацаа дуусаагүй байгаатай холбоотой байна.

Сэлбэг хэрэгслийн /багаж хэрэгсэл/ зардлыг 111,4 сая төгрөгөөр хэмнэсэн нь нийт хэмнэлтэд нөлөөлсөн байна.

Элэгдлийн зардалд 770,0 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 776,1 сая төгрөгийн элэгдэл байгуулсан ба тайлант онд үндсэн хөрөнгө 55,0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь элэгдлийн зардлыг 6,1 сая төгрөгөөр өсгөсөн байна.

Ажиллагсдын нийгмийн зардалд 185,4 сая төгрөг батлагдсанаас 5,5 сая төгрөгийг шагнал урамшуулалд, 51,5 сая төгрөгийг хоолны хөнгөлөлтөд, 20,6 сая төгрөгийг түлшний хөнгөлөлтөд, 2,0 сая төгрөгийг унаа хоолны хөнгөлөлтөд, 16,6 сая төгрөгийг буцалтгүй тусламжид, 80,1 сая төгрөгийг тэтгэмжид, 0,9 сая төгрөгийг эрүүл мэндийн үзлэгт, 8,2 сая төгрөгийг бусад зардалд зарцуулахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 5,4 сая төгрөгийг шагнал урамшуулалд, 37,3 сая төгрөгийг хоолны хөнгөлөлтөд, 10,6 сая төгрөгийг түлээ түлшний хөнгөлөлтөд, 4,2 сая төгрөгийг унаа хоолны хөнгөлөлтөд, 7,7 сая төгрөгийг буцалтгүй тусламжид, 66,3 сая төгрөгийг тэтгэмжид, 0,3 сая төгрөгийг эрүүл мэндийн үзлэгт, 13,6 сая төгрөгийг бусад зардалд зарцуулж батлагдсан төсвийг 40,0 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

Удирдах зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор ажиллагсдын цалинг 10 хувиар нэмэгдүүлэх шийдвэр гарч 4 дүгээр сарын 01-нээс хэрэгжүүлсэн байна. Удирдах зөвлөлөөс баталсан “Жилийн үр дүнгийн шагнал олгох журам”, “Жилийн үр дүнгийн шагнал”-ыг 2,5 сараар тооцож олгохоор шийдвэрлэсэн тогтоолын дагуу ажилчдыг 86,1 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 95 дугаар тогтоолоор “Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨҮААГ-ын цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын зорилтын шаардлагад 2017 онд батлагдсан тарифт тусгагдсан борлуулалтын орлогын шаардагдах хэмжээний /БОШХ/ зардалд багтаж ажиллах талаар тусгасныг хангаж ажилласан байна.

Удирдах зөвлөлийн зардалд 11,6 сая төгрөг батлагдсанаас цалингийн зардалд 9,0 сая төгрөг, НДШимтгэлд 1,2 сая төгрөг, бусад зардалд 1,4 сая төгрөг зарцуулжээ.

Аудитын явцад ХХОАТ-ын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-д “төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, орон тооны бус зөвлөл болон бусад зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүний цалин хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах орлого”, 17 зүйлийн 17.1.-т “энэ хуулийн 11.1.2-11.1.5-д заасан орлогын тухайд нийлбэр дүнгээр ногдуулна гэж заасны дагуу Удирдах зөвлөлийн гишүүдийн цалингаас НДШ-ийг хассан дүнгээс албан татвар ногдуулж, татварын байгууллагад тайлагнажээ. Дутуу суутгасан 0,5 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

### **2.3 Өр, авлагын тооцооны талаар.**

*Олон жил он дамжсан байгууллага, хувь хүмүүсээс авах авлага, найдваргүй авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.*

ЦШСГазар нь 2017 оны эцэст 454,9 сая төгрөгийн авлагатай гарч авлага оны эхнээс 69,8 сая төгрөгөөр нэмэгджээ. Эрчим хүчний зохицуулах хорооны тарифын зохицуулалтаар Цэнгэл сумын төвийн айл өрхүүдийг 250,0 сая төгрөгийн үнэ бүхий электрон тоолуур, СИП кабелиар солих, шугам дэд станцыг шинэчлэх ажил 2018 онд хийгдэхээр болж авлагаар харуулсан нь авлага нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Нийт авлагын 200,8 сая төгрөгийг буюу 44,1 хувийг аж ахуйн нэгж байгууллагын, 153,9 сая төгрөгийг буюу 33,8 хувийг айл өрхөөс авах цахилгааны авлага, 42,8 сая төгрөгийг буюу 9,1 хувийг байгууллага, хувь хүмүүсээс авах бусад авлага, 45,5 сая төгрөгийг буюу 10,0 хувийг найдваргүй авлага, 11,8 сая төгрөгийг буюу 3,0 хувийг ажилчдаас авах авлага тус тус эзэлжээ.

Айл өрхөөс авах цахилгааны авлага оны эхнээс 3,5 хувиар буюу 5,7 сая төгрөгөөр буурч, аж ахуйн нэгжүүдээс авах цахилгааны авлага 54,8 хувиар буюу 71,1 сая төгрөгөөр өссөн байна. Төлбөрөө хугацаанд төлөөгүй ААН-ийн цахилгааныг төлбөр барагдуулах хүртэл хязгаарлах арга хэмжээ авч ажиллаж байгаа боловч үр дүнгээ төдийлөн өгөөгүй байна.

Санхүүгийн тайланд тусгагдсан байгууллага, хувь хүмүүсээс авах бусад авлагыг сүүлийн таван жилээр судалгаа хийж, хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/						
Д/д	Үзүүлэлт	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
1	Хувь хүн	2.0	2.0	2.0	2.0	2.0
2	ААНэгж	37.6	39.6	39.6	39.6	39.6
	<b>Дүн</b>	<b>39.6</b>	<b>41.6</b>	<b>41.6</b>	<b>41.6</b>	<b>41.6</b>

/Эх сурвалж: ЦШСГ-ын тайлангаас/

Энэхүү байгууллага, хувь хүмүүсээс авах авлага нь 2000 оноос дамжиж ирсэн 12 хувь хүн, аж ахуйн нэгжээс авах авлага бөгөөд аж ахуйн нэгж нь татан буугдсан, холбогдох эзэн нь тодорхой бус, нас барсан зэрэг шалтгаанаар дансны авлагаар бүртгэж ирсэн байна./Судалгааг байгууллага, хувь хүний нэрээр гаргаж ажлын баримтад хавсаргаав/

Мөн санхүүгийн тайланд тусгагдсан 45,5 сая төгрөгийн найдваргүй авлага нь 2008 оноос дамжиж ирсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас гарсан захирамж, багийн даргын тодорхойлолт зэрэг нотлох баримттай Казахстан улсад нүүсэн, нас барсан хүмүүстэй холбоотой цахилгааны төлбөрийн авлага байна.

Дээрх байдлаас дүгнэлт хийж үзэхэд олон жил он дамжсан байгууллага, хувь хүмүүсээс авах дансны авлага, найдваргүй авлагыг барагдуулах, шийдвэрлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Ажилчдад олгосон урьдчилгаа, бусад тооцоотой холбоотой оны эхэнд 7,3 сая төгрөгийн авлагатай ба 301,5 сая төгрөгийн урьдчилгаа олгож, 297,2 сая төгрөгийг суутгаж оны эцэст 11,8 сая төгрөгийн ажилчдаас авах авлагатай гарч ажилчдаас авах авлага оны эхнээс 4,5 сая төгрөгөөр өссөн байна.

Жилийн эцэст нийт 2587,7 сая төгрөгийн өглөгтэй гарсаны 2136.6 сая төгрөг буюу 82,5 хувийг нь урт хугацаат, 451,1 сая төгрөг буюу 17,5 хувийг богино хугацаат өр төлбөр эзэлж байна.

Дэлхийн банкны цахилгааны алдагдал бууруулах төслийн хүрээнд 2010 оноос хэрэгжсэн 0.4 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын шинэчлэлийн ажлын санхүүжилттэй холбоотой 2136,6 сая төгрөгийн урт хугацаат зээл бүртгэлтэй байна.

Богино хугацаат өглөг оны эхнээс 20,6 хувиар буюу 117,0 сая төгрөгөөр буурсан байна. Богино хугацаат өглөгийн 264,1 сая төгрөгийг ББЭХС-д, 18,9 сая



төгрөгийг МҮОНТРТ-д өгөх өр, 0,5 сая төгрөгийг ҮЭ-д өгөх өр, 51,8 сая төгрөгийг татварт өгөх өглөг, 115,7 сая төгрөгийг бусад өглөг эзэлж байна.

ББЭХС компанид оны эхэнд 518,0 сая төгрөгийн өглөгтэй байсан ба оны эцэст 264,1 сая төгрөг болж 253,9 сая төгрөгөөр буурчээ. ББЭХС-д өгөх өглөг 2015 оноос жил бүр буурч ирсэн ба тайлант онд 231,0 сая төгрөгийн өглөгийг барагдуулжээ.

2000-2015 онуудад зүй бус алдагдал, цахилгаан дамжуулах агаарын шугамын хулгай их, үнэ тарифт өөрчлөлт ороогүй, нийт цахилгааны борлуулалтын 60 гаруй хувийг айл өрх эзэлж байсан гэх мэт шалтгааны улмаас жил бүр ББЭХС-т өгөх өглөг нэмэгдэж ирсэн байна.

*ББЭХС-ээс сүүлийн 3 жилд авсан цахилгааны тооцоог хүснэгтээр харуулбал:*

№	Онууд	ББЭХС ТӨХК-НААС АВСАН ЦАХИЛГААН /МЯН.КВТ/Ц	ТӨЛӨХ ЁСТОЙ ҮНЭ /САЯ .ТӨГ/	ТӨЛСӨН НЬ /САЯ.ТӨГ/	ЭЗЛЭХ ХУВЬ	ТУХАЙН ЖИЛД +,- ӨӨРЧЛӨЛТ/	ҮЛДЭГДЭЛ
1	2015	38660,9	2350,6	2369,6	100,8	19,0	566,8
2	2016	40711,1	2840,1	2889,0	101,7	48,9	517,9
3	2017	44293,8	4103,4	4334,6	105,6	231,2	264,1

*/Эх сурвалж: ЦШСГ-ын тайлангаас/*

2017 оны эцэст харилцах дансны үлдэгдэл оны эхнээс 76,4 хувиар өссөн буюу нийтдээ 709,0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл гарсан ба оны эцсийн богино хугацаат өглөгийг бүрэн барагдуулах боломжтой байжээ.

## Бүлэг 3

*Дотоод хяналт шалгалт үр нөлөөгүй,  
үр дүн муутай хэрэгжсэн байна.*

### 3. Дотоодын хяналтын талаар.

#### 3.1 Өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад тавих дотоодын хяналтын талаар.

*Сумын салбаруудын арилжааны банк дахь харилцах дансанд оны эцэст 0,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.*

Тус газрын санхүүгийн алба нь ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, оператор нягтлан бодогч гэсэн 3 орон тоогоор ажиллажээ. Ерөнхий нягтлан бодогч нь касс, харилцахын хуулгыг боловсруулж, ерөнхий дэвтэр хөтлөх, байгууллагын тайлан тэнцэл гаргах, санхүүгийн албын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, Тооцооны нягтлан бодогч нь аж ахуй, бараа материалын орлого, зарлага, хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагуудын хоорондын тооцоо, Оператор нягтлан бодогч нь айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад түгээсэн цахилгаан эрчим хүчний үнийн тооцоог тус тус хариуцаж ажиллажээ.

Байгууллагад хөтлөгдвөл зохих нягтлан бодох бүртгэл болон анхан шатны бүртгэлийг дээд байгууллагуудаас батлагдсан холбогдох журмын дагуу бүрэн хөтөлж, санхүүгийн баримт материалыг эмх, цэгцтэй үдэж, архивласан байна.

Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад тавих хяналтыг хэвийн түвшинд хэрэгжүүлж ирсэн байна. ЦШСГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 128 дугаар тушаалаар өмч, хөрөнгө, эд хөрөнгийн тооллого хийх комиссыг томилж, тооллого хийж, үр дүнг тооцож ажилласан байна.

Аудит хийх явцад тус газрын удирдлага, нягтлан бодогч, нярав нартай уулзаж, агуулах, гадна, дотор талын орчны ерөнхий байдлыг явж үзэхэд агуулахад байгаа эд хогшил, бараа материалууд эмх, цэгцтэй, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад тавих хяналтыг хэвийн хэмжээнд явуулж ирсэн байна.

ЦШСГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн №112 тоот тушаалаар өмч хөрөнгийг хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталж, зөвлөлийг 5 гишүүнтэй томилж ажиллуулсан байна.

Өмч хамгаалах байнгын зөвлөл нь тус газрын эзэмшилд байгаа эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах болон шинээр эд хөрөнгө авахтай холбогдон гарах харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах журам болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

2017 оны санхүүгийн тайлангаар Толбо, Дэлүүн, Улаанхус, Цэнгэл, Алтай, Булган сум, Цагааннуур тосгон дахь салбарууд арилжааны банк дахь дансанд нийтдээ 0,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Цаашид сумын салбаруудын арилжааны банк дахь дансны үлдэгдлийг сар, улирлын эцэст газрын төв дансанд хааж, тэг үлдэгдэлтэй гаргаж, мөнгөн хөрөнгийн нэгдсэн удирдлага, хяналтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

### **3.2 Худалдан авах ажиллагааны талаар.**

*Хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим хөрөнгийг орлого аваагүй байна.*

Удирдах зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2017 оны төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгөнд багтаан өөрийн орлогын эх үүсвэрээр хөнгөн тэрэг худалдаж авахыг зөвшөөрсөн байна. Уг шийдвэрийг үндэслэн өөрийн хөрөнгөөр үйлчилгээний зориулалттай “Пикап” автомашин нийлүүлэх ажлыг аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/417 захирамжаар байгуулсан үнэлгээний хороо Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 81 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан харьцуулалтын аргаар ажил худалдан авах жишиг баримт бичгийг ашиглан тендерийн бичиг баримт боловсруулан захиалагчаар батлуулан [www.tender.bogov.mn](http://www.tender.bogov.mn) веб сайтад нийтэлжээ.

Үнэлгээний хорооны дүгнэлтээр “ТММН” ХХКомпаныг тендерийн гүйцэтгэгчээр шалгаруулж, “ТММН” ХХКомпани нь автомашин нийлүүлэх ажлыг бүрэн гүйцэтгэж, 2017 оны 10 дугаар сарын 11-ний өдөр улсын комисст хүлээлгэн өгч, орлогод авч данс, бүртгэлд тусгасан байна.

Өлгий сумын нутаг дэвсгэрт орсон хүчтэй аадар борооны улмаас орон гэргүй болсон иргэдэд зориулж улсын болон гадаад улс орнуудын тусламжаар барьж ашиглалтад оруулсан “Кувейт” хорооллын цахилгаан хангамжийн ажлыг хийж гүйцэтгэж, 12 дугаар сард кассаас 54,0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.

Дээрх хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын Эрчим хүчний сайдын а/2632 тоот албан бичиг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 5/1261 тоот албан тоотоор 2018 оны тарифын саналдаа тусгаж шийдвэрлүүлэхийг зөвшөөрсөн байна.

Энэхүү ажлын зураг төсөв байгаа боловч хүлээн авсан, хүлээлгэн өгсөн хүний гарын үсэггүй хэн авсан нь тодорхойгүй, гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийн баримтгүй, хүлээн авч ашиглалтад оруулсан комиссын акт гараагүй, өндөр хүчдэлийн агаарын шугам, дэд станц болон бусад холбогдох хөрөнгийг данс бүртгэлд орлого аваагүй байна.

Аудитын дүнгээр кассаас бүрдэл дутуу баримтаар зарлага гаргасан 54,0 сая төгрөгийн ажлын гэрээ, гүйцэтгэл, хүлээн авсан комиссын акт зэрэг холбогдох анхан шатны баримтуудыг бүрэн баримтжуулж, хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөв.

Өлгий сумын 6, 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт 2016 онд буусан үеэрт автагдсан айл өрхийг 10 дугаар багт нүүлгэн шилжүүлж, Аймгийн Засаг даргын 2016 оны А/602 дугаар захирамжаар Кувейт улсын 98,3 сая төгрөгийн буцалтгүй тусламжийн хөрөнгөнөөс санхүүжилтийн эх үүсвэрийг гаргаж нэг дэд станц, 6 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, СИП кабелээр айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлыг тус газар хийж гүйцэтгэжээ.

Өлгий сумын 10 дугаар багийн айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг Онцгой байдлын газрын дарга, ЦШСГ-ын дарга нар 2016 оны 7 дугаар сард байгуулж аймгийн Засаг дарга баталгаажуулсан байна. Улсын комиссын 2016 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн актаар ашиглалтад авч, ЦШСГазарт хүлээлгэж өгсөн боловч орлого авч данс бүртгэлд тусгаагүй байна. Дээрх хөрөнгийг орлого авч данс бүртгэлд тусгах талаар албан шаардлага өгөв.

2017 онд 82,8 сая төгрөгийн тусгай зориулалтын материал, сэлбэг хэрэгсэл, 20,5 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, бусад үндсэн хөрөнгө худалдан авсан байна. Тээвэр шатахуун, сэлбэг хэрэгслийг гэрээт газруудаас, төслийн болон аж ахуйн зориулалттай материалыг Хятад улс, бусад байгууллага хувь хүмүүсээс хэрэгцээний дагуу худалдан авчээ.

Аудитаар Хятад улсаас шууд худалдан авалтаар авсан аж ахуйн зориулалттай материалын үнийг тус аймгийн захын цахилгаан хэрэгслэлийн худалдааны газруудаар явж үнийн судалгаа хийж үзэхэд зах зээлийн үнээс 10-30 хувиар хямд үнээр орлого авч бүртгэсэн байна.

Аудитын явцад удирдах зөвлөлийн цалин, худалдан авсан бараа, материал, нүүрсний хөнгөлөлт, шагнал урамшууллын дүнгээс дутуу суутгасан 4,9 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

### **3.3. Байгууллагын дотоодын хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн талаар**

*Дотоод хяналтын ажилтны хийсэн ажлын тайланг Удирдах зөвлөлөөр хэлэлцэж, дүгнээгүй байна*

Тус газрын үйл ажиллагааны чиглэл нь үндсэн 4 нэгжид хувааж, нэгжүүд хоорондоо харилцан хамааралтай ажиллахаар зохион байгуулагдсан байна.

Борлуулалтын алба, санхүүгийн албатай хамтран айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад түгээсэн цахилгаан эрчим хүчний төлбөрийн барагдуулалтыг хариуцаж, тус тусдаа хөтөлж буй програмууд нь нэгтгэгдэж, санхүүгийн албыг мэдээллээр хангах түвшинд зохион байгуулагдсан байна

Санхүүгийн программ нь 4 хэсгээс бүрддэг ба "Payable", "Market indicator", "cass service" зэрэг хэсгийг борлуулалтын алба нь ашиглаж, хэрэглэгчийн болон борлуулалтын үйл ажиллагаатай холбоотой бүх мэдээллийг оруулж, "Апекс" программд дээрх бүх мэдээллийг татаж, санхүүгийн бусад үйл ажиллагааг оруулж нэгтгэснээр цогц мэдээлэл нэг дор цахимаар гарч, санхүүгийн тайлан гарах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Цахилгааны борлуулалтын үйл ажиллагааг сар бүр 4 долоо хоногоор төлөвлөж, дөрвөн циклээр зохион байгуулж ажилласан байна. Хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний бичилт хийх, нэхэмжлэл мэдээлэл хүргэх, цахилгаан эрчим хүчний төлбөрийг барагдуулах үйл ажиллагаанд шат шатандаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, орон сууцны хэрэглэгчдийн цахилгааны тухайн үеийн заалтын бичилтийг оператор-нягтлан бодогч компьютерт оруулж илгээсний дараа борлуулалтын инженер хянадаг бол айл өрхийн хэрэглэгчдийн цахилгааны бичилтийг алсын удирдлагын /ТУГУБ/ багажаар заалт авагчаар авч ирсний дараа оператор, нягтлан бодогч компьютерт уншуулж, борлуулалтын программд холбож

борлуулалтын инженер заалт авагч бүрээр бичилтийн цэгийн гүйцэтгэлийн тайлан гаргаж албаны даргад хянуулдаг байна.

Цахилгааны хэрэглэгч айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага нь хэрэглэсэн цахилгааны үнэ төлбөрийг хугацаанд нь төлөөгүй нөхцөлд цахилгааны хязгаарлалт хийж цахилгааны төлбөрийг хугацаанд нь төлүүлэх арга хэмжээ авч ажиллаж байгаа нь борлуулалтын орлого тухайн сард ороход нөлөөлсөн байна.

Тайлант онд Өлгий сумын ухаалаг тоолуурын системд шилжиж тусгай сервер, программ хангамжтай болсон нь дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд зохих үр дүнгээ өгсөн байна

Сар бүр цахилгаан хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад нэхэмжлэл хүргүүлж, айл өрхийн хэрэглэгчдэд төлбөрийн мэдээллийг хэрэглэгчдийн гар утсанд мессежээр илгээдэг байна. Авлагын мэргэжилтэн өдөр бүр циклийн дагуу төлбөрөө хугацаанд нь төлөөгүй хэрэглэгчдийн жагсаалтыг гаргаж албаны даргаар хянуулж, авлага барагдуулагч нарт цахилгаан хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчийг Эрчим хүчний тухай хуулийн 32.2.1-д заасны дагуу түр хугацаагаар түдгэлзүүлэх даалгавар өгдөг байна. Нөгөө талаар авлагын хэсэг нь долоо хоног бүрийн баасан гаригт цахилгаан эрчим хүчийг түдгэлзүүлсэн хэрэглэгчдийн цахилгаан сүлжээнд байнгын хяналт тавьж ажиллаж ирсэн байна.

Хэрэглэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдол болон хяналт шалгалтын ажлын хэсгийн дүгнэлтээр тоолуурын ээлжит ба ээлжит бус баталгаажуулалтыг аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран хийж, бүх цахилгаан хэрэглэгчдийн товч, дэлгэрэнгүй мэдээллийг борлуулалтын программаар шууд гаргах боломжтой болсон байна.

Цахилгаан хэрэглэгчдийн хэрэглээний мэдээлэл, борлуулалтын үйл ажиллагааны мэдээллийг өдөр, сар, жилээр гаргах боломжтой болсон тул борлуулалтын үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтад хүндрэл гарахгүй болж борлуулалтын үйл ажиллагааны хяналт сайжирч зохих үр дүнгээ өгсөн байна

Газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулж, удирдамж батлуулан Цэнгэл, Дэлүүн, Баяннуур сумуудын борлуулалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, шалгалтын үр дүнг тооцож ажилласан байна.

Удирдах зөвлөлийн 2017 оны 03 дугаар тогтоолоор дотоод хяналт шинжилгээний ажилтны “Дотоод хяналт шалгалтын журам”-ыг баталсан байна. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах 2017 оны ажлын төлөвлөгөөг Удирдах зөвлөлийн даргаар батлуулсан байна. Төлөвлөгөөнд 8 төрлийн ажлыг хийж гүйцэтгэхээр тусгажээ.

Дотоод хяналт шинжилгээний ажилтан нь тайлант онд Алтай сумын цахилгаан эрчим хүчний үлдэгдлийг баталгаажуулах тооцоо хийж, сумын монтер цахилгааны үнийг хувьдаа ашигласныг нөхөн төлүүлж, 2017 оны 8-12 дугаар сарын кассын орлого, зарлага үлдэгдлийг тулган шалгаж баталгаажуулах, 1,2 дугаар улирлын шатахууны зарцуулалт, бараа материалын худалдан авалт, ХАОАТ-ын ногдуулалт төлөлтийн тооцоог шалгаж, ажлын тайлан бичсэн байна. Гэхдээ Дотоод хяналтын ажилтны хийсэн ажлын тайланг Удирдах зөвлөлөөр хэлэлцэж, дүгнээгүй байна.

Үүнээс үзэхэд Удирдах зөвлөлөөс томилсон дотоод шалгалт нь үр нөлөөгүй, үр дүн муутай хэрэгжсэн байна.

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

### **1. Цахилгаан шугам сүлжээний газрын үндсэн үйл ажиллагааны зорилтын хэрэгжилтийн талаар.**

- Удирдах зөвлөлөөс 2017 оны үйл ажиллагааг “хангалттай” гэж дүгнэжээ.
- Хөдөө сумдын цахилгааны алдагдал 34,4 хувьтай байгаа нь нийт алдагдлын хувьд нөлөөлсөн байна.

### **2. Орлогын бүрдүүлэлт, хөрөнгийн зарцуулалтын талаар.**

- Цахилгааны худалдан авах, түгээх үйлчилгээний үнэ тариф өссөн нь борлуулалт өсөхөд нөлөөлсөн байна.
- Үйл ажиллагааны зардлыг 171,2 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.
- Олон жил он дамжсан байгууллага, хувь хүмүүсээс авах авлага, найдваргүй авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

### **3. Дотоодын хяналтын талаар.**

- Сумын салбаруудын арилжааны банк дахь харилцах дансанд оны эцэст 0,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.
- Хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим хөрөнгийг орлого аваагүй байна.
- Дотоод хяналт шалгалт үр нөлөөгүй, үр дүн муутай хэрэгжсэн байна.

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

### **УЗ-ийн дарга, аймгийн ИТХ-ын дарга Д.Бауыржан танаа:**


1. Дотоод хяналт шинжилгээний ажилтны ажлын тайланг жил бүр хэлэлцэж, дүгнэх, дотоод хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх.
2. Төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын хандив тусламжийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг орлого авч данс бүртгэлд тусгуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.

### **Цахилгаан шугам сүлжээний газрын дарга Ж.Керейд:**

1. Хөдөө сумдын цахилгааны алдагдлыг бууруулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах
2. Байгууллага, хувь хүмүүстэй холбоотой олон жил он дамжсан авлага, найдваргүй авлагыг барагдуулах, шийдвэрлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.
3. Сумын салбаруудын арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдлийг сар, улирлын эцэст тэг үлдэгдэлтэй гаргаж байх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

## Холбогдох байгууллагын санал

### Холбогдох байгууллагын санал





**ТАЙЛАНГ ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

**ТАЙЛАНГ ХЯНАСАН**

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

**ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР

Х.МАНАРГҮЛ

АУДИТОР

Б.ЕРКЕБУЛАН